

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: (САГ-2019/174/СТА-УТҮГ)

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
	2.1. Оршил.....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	9
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	9
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	10
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
	2.11. Шилэн дансны мэдээлэл	10
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	17
	4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	17
	4.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан.....	20
	4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	25
	4.4 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	225
	4.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	226
5	Зөрчлийн нэгтгэл.....	28



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/435
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН
“НАЙРАМДАЛ” ЦОГЦОЛБОРЫН
ЗАХИРАЛ О.ДОРЖСҮРЭН
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн.

Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолбор нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын захирал О.Доржсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 25-наас 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрүүдэд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, "Пийк ОМ Аудит" ХХК-ийн аудитор А.Мөнхцэцэг, Н.Цэнгэнбаяр, З.Цэцгээ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолбор 2018 оны санхүүгийн тайланг "Пийк ОМ Аудит" ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 38 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолбор нь "Хүүхэд бүрийг нийгмийн харилцааны үнэт баялаг, үндэсний ёс заншлаас суралцуулах, хүүхдийн эрхэд суурилсан хөгжлийг дэмжих, тэдний амарч хөгжих, эрүүл, таатай орчинг бүрдүүлэх, чанартай хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх хөгжлийн хөтөлбөрийн арга зүйг дэлгэрүүлэхэд оршино" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Хүүхэд, өсвөр, залуу үеийнхнийг нас, хөгжлийн онцлогт тохирсон

хөгжлийн хөтөлбөрөөр үйлчлэх, хөгжлийг нь дэмжих, зуслан, хөгжлийн ордон, төвүүдийг арга зүйгээр хангах чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг. Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолбор санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт "үр нөлөөтэй" гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт орлогын 1.0 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус байгууллагын орлогын ихэнх хувийг өөрийн орлого эзэлдэгтэй холбоотой юм.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын 2018 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт орлого 4,788.7 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 47.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 11 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 10 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Эхний хагас жилийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн 218.4 сая төгрөгийн элэгдэл байгуулаагүй.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	7	58.6	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1.5	
3	Албан шаардлага өгсөн	2		
	Дүн	10	60.2	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: (Зардлын данс)

Ажилчдын байр болон цогцолбор орчмын амины орон сууц, аж ахуй нэгж усны тоолуур байхгүйн улмаас нийт дүнгээр нь усны зардалдаа тусгаж төлж улмаар усны зардал хэтэрсэн байна.

Шийдэл: Зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх

Асуудал 2: (Зардлын данс)

“Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-нд багтаагүй албан тушаал хашдаг, тус цогцолборын 3 дэд захирал суудлын автомашин хэрэглэж байна. Энэ нь Засгын газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралттай нийцэхгүй байна.

Шийдэл: Зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх

Асуудал 3: (Цалингийн зардал)

Тус байгууллагын захирал эрх бүхий албан тушаалтаны шийдвэргүйгээр 1.5 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал авсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдэл: Урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Ажилчдын байр болон цогцолбор орчмын амины орон сууц, аж ахуй нэгж усны тоолуур байхгүйн улмаас нийт дүнгээр нь усны зардалдаа тусгаж төлж улмаар усны зардал хэтэрсэн байна. Цаашид бүрэн тоолууржуулж усны зарцуулалтанд хяналт тавих шаардлагатай байна.

Ажиллагсдын гарт олгох цалингийн жагсаалтыг банкны теллерийн тамга тэмдгээр баталгаажуулж санхүүгийн баримтанд хавсаргаагүй байна. Энэ нь хүмүүсийн цалин гарт үнэн зөвөөр олгогдож байгаа эсэхийг хянах боломжгүй байдал үүсгэх эрсдэлтэй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд төсвөөс урсгал санхүүжилт 497.0 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 497.0 сая мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3805.6 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3769.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 398.8 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 386.5 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Нийт 4701.5 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 99.3 хувиар биелүүлж 4673.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн. Үүнээс 4673.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолбор Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тухайлбал нийт 2,632.2 сая төгрөгийн орлогын мэдээ, 1,970.4 сая төгрөгийн зарлагын мэдээ зэрэг нийт 107 мэдээг байршуулснаас 99 мэдээг хугацаанд нь Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолбор 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нэг удаагийн буцалтгүй тусламж, шагнал урамшуулалтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын захирлын Б/35, Б/44 тоот тушаалуудаар 2 дэд захиралд 1.1 сая төгрөгийн буцалтгүй тусламж тус тус олгосон. Тушаалд дурьдсан хамтын гэрээний 8.4.6 дах заалтад хамаарахгүй тохиолдолд зааснаас их, хамтын гэрээний 8.4.8 дах заалтаас их тэтгэмж тус тус өгсөн.

3.1.2 Эрсдэл:

Зардал хэтрэх, үр дүн буурах эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Орлогын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тус цогцолборын Марал буудлын орлогыг 5.2 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн. Энэ нь Нягтлан бодо бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5.”Бүх орлого”-г нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Тайлант хугацааны үр дүн буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй байна.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Хүнсний материалтай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, ногоо олж бэлтгэснээс 1.9 сая төгрөгийн хүнс акталсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Хоолны зардал хэтрэх, үр дүн буурах эрсдэлтэй.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

3.4 Цалингийн зардалтай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Тус цогцолборын захирлын А/74 тоот тушаалаар нийт ажилчдад цалингийн зардлаас 17.0 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгохдоо 1.5 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй. Энэ нь

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1.”Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”-д албан татвар ногдуулна гэж заасантай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Хууль тогтоомж зөрчигдөх, татварын эрсдэлд орох.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

3.5 Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

40 жилийн ойн концертонд дуулсан дуучид, хөтлөгчийн 1.1 сая төгрөгийг олгохдоо гарын үсэг зурж баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.”Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7.”Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ журналд тусгагдах эрсдэлтэй.

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

3.6 Жижиг мөнгөн сантай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Худалдан авалтын төсөв, дараа тайлангийн тооцоо, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл, захирлын зөвлөлөөс гаргасан шийдвэргүйгээр Жижиг мөнгөн сангаас 42.6 сая төгрөгийн зөөлөн эдлэл, шил шаазан, барилгын засварын материал зэргийг БНХАУ-аас худалдаж авсан. Мөн жижиг мөнгөн сангаас захирлын А/53 тоот тушаалаар овоо тахихад 1.0 сая төгрөг зарцуулсан. Үүний 0.4 сая төгрөгийг нэг удаагийн буцалтгүй тусламж, шагнал урамшууллын зардлаас, 0.6 сая төгрөгийг хоолны зардлаас тус тус зарцуулсан.

Жижиг мөнгөн сангаас Үндсэн хөрөнгө худалдаж авсан. Гэр хотхонд зориулан 0.8 сая төгрөг зарцуулж Нарантуулаас гэр худалдаж авсан.

3.6.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг зөрчигдөх, хөрөнгө үрэгдэх эрсдэлтэй.

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

3.7 Зардлын данстай холбоотой асуудал

3.7.1 Илрүүлэлт:

2017 оны харшийн шинэ жилийн найруулагчийн хөлс 2.5 сая төгрөгийг 2018 оны 1 дүгээр сарын 05-нд олгож 2018 оны зардлаар тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.”Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.”, 14 дүгээр зүйлийн 14.4.6.”Бүх зардал”-г нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Нүүрсний зарцуулалтыг тайлагнах журмын дагуу өдөр тутмын зарцуулалтыг 7 сараас хэрэгжүүлэн бүртгэж эхэлсэн байна. Мөн нүүрсийг аж ахуйн материал дансанд бүртгэж байна.

3.7.2 Эрсдэл:

Санхүүгийн байдал болон тайлант хугацааны үр дүн буруу илэрхийлэгдэх, нүүрсний зардал хэтрэх, зарцуулалтыг хянах боломжгүй байдал үүсэх эрсдэлтэй.

3.7.3 Өгсөн зөвлөмж:

Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>630,698,881.73</u>	<u>802,514,314.86</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,006,462.63	351,928.79
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	9,884.52	0.00
31110	Төгрөг	9,884.52	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	996,578.11	351,928.79
3121	Төгрөг	996,578.11	351,928.79
31211	Төрийн сангийн харилцах	996,578.11	351,928.79
33	АВЛАГА	99,580,164.20	88,783,870.35
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,455,000.00	10,874,623.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	44,653,500.00	52,187,600.00
335	Бусад авлага	53,471,664.20	25,721,647.35
3351	Байгууллагаас авах авлага	53,381,734.20	25,721,647.35
3352	Хувь хүмүүсээс авах авлага	89,930.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	38,778,708.00	39,250,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	37,609,000.00	39,000,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	1,169,708.00	250,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	1,169,708.00	250,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	491,333,546.90	674,128,515.72
351	Түүхий эд материал	94,750.00	446,342.63
35130	Эм боох материал	94,750.00	446,342.63
354	Хангамжийн материал	491,238,796.90	673,682,173.09
35420	Аж ахуйн материал	87,203,008.04	175,074,110.62
35430	Сэлбэг хэрэгсэл	4,170,600.00	957,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,864,100.00	1,808,350.00
35460	Хүнсний материал	24,998,441.53	30,748,531.64
35470	Бусад хангамжийн материал	372,002,647.33	465,094,180.83
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,056,336,602.27</u>	<u>15,158,334,805.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,056,336,602.27	15,158,334,805.60

392	Биет хөрөнгө	7,052,830,560.64	15,008,111,605.81
3920 1	Барилга, байгууламж, орон сууц	16,019,872,408.00	13,539,043,729.00
3920 2	Хуримтлагдсан элэгдэл	(10,120,351,239.63)	(6,484,537.62)
3920 3	Авто-тээврийн хэрэгсэл	532,597,446.70	407,183,476.70
3920 4	Хуримтлагдсан элэгдэл	(376,250,358.65)	(328,996,252.55)
3920 5	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,694,292,718.09	1,786,045,481.66
3920 6	Хуримтлагдсан элэгдэл	(954,890,663.73)	(1,071,461,219.09)
3920 7	Тавилга, аж ахуйн эд хогшил	653,751,311.97	723,986,359.56
3920 8	Хуримтлагдсан элэгдэл	(473,595,455.00)	(492,612,466.14)
3921 4	Бусад үндсэн хөрөнгө	554,328,188.53	514,765,693.53
3921 5	Хуримтлагдсан элэгдэл	(476,923,795.64)	(63,358,659.24)
393	Биет бус хөрөнгө	3,506,041.63	150,223,199.79
3930 1	Програм хангамж	8,692,044.00	8,692,044.00
3930 2	Хуримтлагдсан элэгдэл	(8,186,002.21)	(8,552,044.00)
3930 3	Бусад биет бус хөрөнгө	5,000,000.00	152,708,200.00
3930 4	Хуримтлагдсан элэгдэл	(2,000,000.16)	(2,625,000.21)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,687,035,484.00</u>	<u>15,960,849,120.46</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>253,828,991.31</u>	<u>647,489,620.94</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	253,828,991.31	647,489,620.94
413	Өглөг	246,984,846.31	495,123,268.94
4131 0	Ажилчидтай холбогдсон өглөг	45,874,422.21	199,703,968.29
4132 0	Бараа үйлчилгээний зардлын өглөг	199,454,525.10	269,186,600.65
4136	Бусад өглөг	1,655,899.00	26,232,700.00
4136 1	Байгууллагад төлөх өглөг	1,605,100.00	26,232,700.00
4136 2	Хувь хүмүүст төлөх өглөг	50,799.00	0.00
414	Урьдчилж орсон орлого	6,844,145.00	152,366,352.00
4142 0	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	6,844,145.00	152,366,352.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,433,206,492.69</u>	<u>15,313,359,499.52</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,433,206,492.69	15,313,359,499.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,063,454,256.84	6,201,162,456.84
5110 1	Өмч: - төрийн	6,063,454,256.84	6,201,162,456.84

512	Хуримтлагдсан үр дүн	(2,282,336,261.17)	(2,495,051,723.38)
5121 0	Өмнөх үеийн үр дүн	(2,282,336,261.17)	(2,282,336,261.17)
5122 0	Тайлант үеийн үр дүн	0.00	(212,715,462.21)
5130 0	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,652,088,497.02	11,607,248,766.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,687,035,484.00</u>	<u>15,960,849,120.46</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,787,070,912.94	4,788,729,021.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,324,380,250.94	4,099,860,876.94
120	Нийтлэг татварын бус орлого	2,281,553,830.94	4,066,471,003.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,199,019,346.44	4,009,722,910.67
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,945,935,644.00	3,593,362,865.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	253,083,702.44	416,360,045.17
120005	Түрээсийн орлого	5,761,400.00	3,568,000.00
120009	Бусад орлого	76,773,084.50	53,180,093.27
122	Тусламжийн орлого	42,826,420.00	33,389,873.00
122001	Хандив тусламж /дотоод/	42,826,420.00	33,389,873.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	462,690,662.00	688,868,145.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	372,778,600.00	497,038,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	372,778,600.00	497,038,200.00
1330	Төсвийн захирагчдаас	89,912,062.00	191,829,945.00
133003	Хөрөнгийн	89,912,062.00	191,829,945.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,392,625,930.88	4,973,210,806.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,392,625,930.88	4,973,210,806.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,385,664,430.88	4,930,953,822.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	783,273,080.07	1,324,556,852.52
210101	Үндсэн цалин	712,326,914.07	1,190,301,221.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,618,000.00	54,623,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,328,166.00	79,632,631.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,794,760.60	158,827,257.64
210201	Тэтгэврийн даатгал	55,116,349.60	109,290,577.64
210202	Тэтгэмжийн даатгал	6,782,821.00	12,916,614.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,494,928.00	10,162,411.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,989,946.00	2,376,605.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,410,716.00	24,081,050.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	381,597,084.75	706,627,981.88
210301	Гэрэл, цахилгаан	136,429,240.91	262,275,364.70
210302	Түлш, халаалт	135,290,770.00	219,024,329.41
210303	Цэвэр, бохир ус	109,877,073.84	225,328,287.77
2104	Хангамж, бараа материалын зардал	155,241,024.74	410,903,782.52
210401	Бичиг хэрэг	10,023,968.00	15,905,129.75
210402	Тээвэр, шатахуун	81,702,850.00	184,013,470.00

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,654,731.12	15,276,955.23
210404	Ном, хэвлэл	0.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,865,110.00	6,849,278.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,462,511.62	117,237,470.51
210408	Бараа материал акталсны зардал	5,531,854.00	71,521,479.03
2105	Нормативт зардал	568,305,054.43	1,312,250,127.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,434,700.00	2,468,137.37
210502	Хоол, хүнс	563,938,095.43	1,251,628,407.49
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,932,259.00	58,153,583.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,794,176.00	212,891,459.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	139,990.00	19,211,716.00
210602	Тавилга	0.00	38,753,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,052,000.00	6,067,686.00
210604	Урсгал засвар	83,602,186.00	148,858,257.60
2107	Томилолт, зочны зардал	250,000.00	24,812,217.80
210701	Гадаад албан томилолт	0.00	24,812,217.80
210702	Дотоод албан томилолт	250,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,756,249.59	93,248,751.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,291,900.00	69,166,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	7,482,880.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,981,250.00	6,834,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,218,700.00	1,139,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	286,000.00	1,118,724.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	6,086,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	478,399.59	1,419,317.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	297,653,000.70	686,835,391.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,854,475.90	98,617,544.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,982,703.02	132,237,491.55
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	258,815,821.78	455,980,355.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,961,500.00	42,256,984.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,961,500.00	42,256,984.30
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,961,500.00	42,256,984.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>394,444,982.06</u>	<u>(184,481,784.76)</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	6,975,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	0.00	6,975,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	35,208,677.45
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	0.00	35,208,677.45
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	(28,233,677.45)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>394,444,982.06</u>	<u>(212,715,462.21)</u>

4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,671,546,657.07</u>	<u>4,666,035,952.04</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,215,928,407.07	4,168,997,752.04
120	Нийтлэг татварын бус орлого	3,215,728,407.07	4,155,687,752.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,205,102,067.93	4,148,232,764.77
200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,946,330,410.00	3,769,093,935.40
200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	258,771,657.93	379,138,829.37
120005	Түрээсийн орлого	4,905,000.00	4,138,000.00
120009	Бусад орлого	5,721,339.14	3,316,987.27
121	Хөрөнгийн орлого	200,000.00	00.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө рлуулсны орлого	200,000.00	00.00
122	Гуламжийн орлого	00.00	13,310,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	13,310,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	455,618,250.00	497,038,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	455,618,250.00	497,038,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	455,618,250.00	497,038,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,602,295,924.72</u>	<u>4,454,212,385.88</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,602,295,924.72	4,454,212,385.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,573,128,767.72	4,411,904,985.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,195,541,416.90	1,153,723,616.75
210101	Үндсэн цалин	1,162,806,682.90	1,019,467,985.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,105,000.00	54,623,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,629,734.00	79,632,631.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	159,750,718.60	148,492,487.63
210201	Тэтгэврийн даатгал	127,732,659.60	98,955,807.63
210202	Тэтгэмжийн даатгал	12,659,518.00	12,916,614.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,504,700.00	10,162,411.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,766,134.00	2,376,605.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,087,707.00	24,081,050.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	602,015,667.50	706,627,981.88
210301	Гэрэл, цахилгаан	216,278,817.06	262,275,364.70
210302	Түлш, халаалт	213,985,562.00	219,024,329.41
210303	Цэвэр, бохир ус	171,751,288.44	225,328,287.77

Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	241,632,394.32	317,601,225.23
210401	Бичиг хэрэг	9,639,250.00	14,673,720.00
210402	Тээвэр, шатахуун	127,653,257.50	158,132,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,566,994.32	15,276,955.23
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,155,910.00	6,849,278.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	83,480,132.50	114,708,972.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	7,860,000.00
2105	Нормативт зардал	1,022,336,514.00	1,415,683,825.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,299,600.00	2,169,600.00
210502	Хоол, хүнс	926,417,646.00	1,249,754,379.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	93,619,268.00	163,759,846.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	223,513,015.00	218,496,038.59
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,016,070.00	3,418,960.00
210602	Тавилга	123,000.00	24,795,821.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	225,000.00
210604	Урсгал засвар	219,373,945.00	190,056,257.59
2107	Томилолт, зочны зардал	2,074,585.00	15,678,256.00
210701	Гадаад албан томилолт	1,624,585.00	15,678,256.00
210702	Дотоод албан томилолт	250,000.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	200,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, раамж	41,894,888.40	89,276,954.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,009,518.40	67,697,804.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	6,702,120.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,981,250.00	6,834,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,218,700.00	1,139,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	286,000.00	1,040,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,705,220.00	5,206,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	494,200.00	655,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,369,568.00	346,324,600.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,523,877.00	121,960,296.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,845,691.00	224,364,303.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,167,157.00	42,307,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,167,157.00	42,307,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,966,457.00	42,307,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>69,250,732.35</u>	<u>211,823,566.16</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	6,975,000.00

140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	00.00	6,975,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	51,516,700.00	219,453,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	51,516,700.00	219,453,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	51,516,700.00	219,453,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,516,700.00	219,453,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-51,516,700.00</u>	<u>-212,478,100.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,734,032.35	-654,533.84
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,966,040.20	1,006,462.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,249,238.55	351,928.79

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,063,454,256.84	3,652,088,497.02	(2,484,924,369.92)	0.00	7,230,618,383.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	202,588,108.75	0.00	202,588,108.75
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,063,454,256.84	3,652,088,497.02	(2,282,336,261.17)	0.00	7,433,206,492.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,063,454,256.84	3,652,088,497.02	(2,282,336,261.17)	0.00	7,433,206,492.69
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	7,955,160,269.04	0.00	0.00	7,955,160,269.04
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	137,708,200.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(212,715,462.21)	0.00	(75,007,262.21)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,201,162,456.84	11,607,248,766.06	(2,495,051,723.38)	0.00	15,313,359,499.52

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4481550425.00	4454212385.68	(27338039.32)	99.39
2	УРСГАЛ ЗАРДАЛ	4481550425.00	4454212385.68	(27338039.32)	99.39
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4429050425.00	4411904985.68	(17145439.32)	99.61
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1166088509.00	1153723616.55	(12364892.45)	98.94
5	Үндсэн цалин	1029850104.00	1019467985.55	(10382118.45)	98.99
6	Нэмэгдэл	80103405.00	79632631.00	(470774.00)	99.41
7	Унаа хоолны хөнгөлөлт	56135000.00	54623000.00	(1512000.00)	97.31
8	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148637806.00	148492487.63	(145318.37)	99.90
9	Тэтгэврийн даатгал	99101126.00	98955807.63	(145318.37)	99.85
10	Тэтгэмжийн даатгал	12916614.00	12916614.00	0.00	100.00
11	ҮОМШӨ-ний даатгал	10162411.00	10162411.00	0.00	100.00
12	Ажилгүйдлийн даатгал	2376605.00	2376605.00	0.00	100.00
13	Эрүүл мэндийн даатгал	24081050.00	24081050.00	0.00	100.00
14	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	694630912.00	706627981.88	11997069.88	101.73
15	Гэрэл, цахилгаан	254104205.00	262275364.70	8171159.70	103.22
16	Түлш, халаалт	220111450.00	219024329.41	(1087120.59)	99.51
17	Цэвэр, бохир ус	220415257.00	225328287.77	4913030.77	102.23
18	Хангамж, бараа материалын зардал	322268611.00	317601225.23	(4667385.77)	98.55
19	Бичиг хэрэг	15254605.00	14673720.00	(580885.00)	96.19
20	Тээвэр, шатахуун	159506500.00	158132300.00	(1374200.00)	99.14
21	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17203000.00	15276955.23	(1926044.77)	88.80
22	Ном, хэвлэл	100000.00	100000.00	0.00	100.00
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7000000.00	6849278.00	(150722.00)	97.85
24	Аж ахуйн материал худалдан авах зардал	8000000.00	7860000.00	(140000.00)	98.25
25	Бага үнэнтэй түргэн элэгдэх зүйл	115204506.00	114708972.00	(495534.00)	99.57
26	Нормативт зардал	1418123087.00	1415683825.40	(2439261.60)	99.83
27	Эм бэлдмэл, Эмнэлэгийн хэрэгсэл	2400000.00	2169600.00	(230400.00)	90.40
28	Хоол, хүнс	1251303120.00	1249754379.40	(1548740.60)	99.88
29	Нормын хувцас, зөөлөн эдлэл	164419967.00	163759846.00	(660121.00)	99.60
30	Эд хогшил, урсгал засварын зардал	221145000.00	218496038.59	(2648961.41)	98.80

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

31	БАгаж, техник хэрэгсэл	3500000.00	3418960.00	(81040.00)	97.68
32	Тавилга	25000000.00	24795821.00	(204179.00)	99.18
33	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	300000.00	225000.00	(75000.00)	75.00
34	Урсгал засвар	192345000.00	190056257.59	(2288742.41)	98.81
35	Томилолт, зочны зардал	16000000.00	15678256.00	(321744.00)	97.99
36	Гадаад албан томилолт	16000000.00	15678256.00	(321744.00)	97.99
37	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92400000.00	89276954.00	(3123046.00)	96.62
38	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68000000.00	67697804.00	(302196.00)	99.56
39	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8000000.00	6702120.00	(1297880.00)	83.78
40	Даатгалын үйлчилгээ	7000000.00	6834930.00	(165070.00)	97.64
41	Тээврийн хэрэгслийн татвар	1500000.00	1139500.00	(360500.00)	75.97
42	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1200000.00	1040400.00	(159600.00)	86.70
43	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6000000.00	5206500.00	(793500.00)	86.78
44	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	700000.00	655700.00	(44300.00)	93.67
45	Бараа үйлчилгээний бусад зардал	349756500.00	346324600.40	(3431899.60)	99.02
46	Бараа үйлчилгээний бусад зардал	124256500.00	121960296.60	(2296203.40)	98.15
47	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	225500000.00	224364303.80	(1135696.20)	99.50
48	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52500000.00	42307400.00	(10192600.00)	80.59
49	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	52500000.00	42307400.00	(10192600.00)	80.59
50	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	220000000.00	219453100.00	(546900.00)	99.75
51	Дотоод эх үүсвэрээр	220000000.00	219453100.00	(546900.00)	99.75
52	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4701550425.00	4673010952.04	(28539472.96)	99.39
53	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	497038200.00	497038200.00	0.00	100.00
54	Улсын төсвөөс санхүүжих	497038200.00	497038200.00	0.00	100.00
55	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4204512225.00	4175972752.04	(28539472.96)	99.32
56	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3805687899.00	3769093935.40	(36593963.60)	99.04
57	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	398824326.00	386593816.64	(12230509.36)	96.93
58	Бусад эх үүсвэр		20285000.00	20285000.00	
59	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1006462.63	1006462.63	0.00	100.00
60	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	351928.79	351928.79	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	158.00	147.00	(11.00)	93.04

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	2019-03-14	Аудитын нэр	Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
Шалгалдсан байгууллагын нэр:	Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолбор			САГ-2019/11/СТА-УТҮГ
				Сая төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5			9	10
1	Зардлын данстай холбоотой	3	Тус цогцолборын 3 дэд захирал “Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-нд багтаагүй албан тушаал хашдаг боловч суудлын автомашин хэрэглэж байна.		албан шаардлага	2019.03.14		Захирал, Ерөнхий нягтлан бодогч	О.Доржсүрэн, М.Баярмаа
2	Зардлын данстай холбоотой		Ажилчдын байр болон цогцолбор орчмын амины орон сууц, аж ахуй нэгж усны тоолуур байхгүйн улмаас нийт дүнгээр нь усны зардалдаа тусгаж төлж улмаар усны зардал хэтэрсэн байна.		албан шаардлага	2019.03.14		Захирал, Ерөнхий нягтлан бодогч	О.Доржсүрэн, М.Баярмаа
3	Цалингийн зардалтай холбоотой	1	Захирал О.Доржсүрэн эрх бүхий албан тушаалтаны шийдвэрүйгээр үр дүнгийн урамшуулал авсан	1.5	акт тогтоох	2019.03.14		Захирал, Ерөнхий нягтлан бодогч	О.Доржсүрэн, М.Баярмаа
4	Нэг удаагийн буцалтгүй тусламж, шагнал урамшуулал	2	2 дэд захиралд тус байгууллагын захирлын Б/35, Б/44 тоот тушаалуудаар 1100000-н буцалтгүй тусламж тус тус олгосон. Б/33 дугаар тушаалд дурьдсан хамтын гэрээний 8.4.6 дах заалтад хамаарахгүй тохиолдолд зааснаас их тэтгэмж өгсөн. Б/44	1.7	Зөвлөмж өгөх	2019.03.14		Захирал, Ерөнхий нягтлан бодогч	О.Доржсүрэн, М.Баярмаа

			тоот тушаалд дурьдсан хамтын гэрээний 8.4.8 дах заалтаас их тэтгэмж өгсөн.					
5	Орлогын данстай холбоотой	1	Марал буудлын орлогыг дутуу илэрхийлсэн. /Хоолны үйлчилгээний журам-8.5 Захирал сард 1 удаа, дэд захирлууд улиралд 1 удаа 250000-н үйлчилгээ авах эрхтэй/	5.2	Зөвлөмж өгөх	2019.03.14		Захирал, Ерөнхий нягтлан бодогч О.Доржсүрэн, М.Баярмаа
6	Хүнсний материалт ай холбоотой	1	Хүнсний материал акталсан байна. Шаардлага хангахгүй хатаасан ногоо олж бэлтгэснээс 1900.0 мянган төгрөгийн хүнс акталсан байна.	1.9	Зөвлөмж өгөх	2019.03.14		Захирал, Ерөнхий нягтлан бодогч О.Доржсүрэн, М.Баярмаа
7	Цалингийн зардалтай холбоотой	1	A/74 тоот тушаалаар нийт ажилчдад цалингийн зардлаас 17040000 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон. ХХОАТ суутгаагүй.	1.5	Зөвлөмж өгөх	2019.03.14		Захирал, Ерөнхий нягтлан бодогч О.Доржсүрэн, М.Баярмаа
8	АШБ-ын бүрдэлтэй холбоотой	1	2018 оны 07 сарын 18-ны өдрийн 40 жилийн ойн концертонд дуулсан дуучид, хөтлөгчийн мөнгийг олгохдоо гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тайлангүй.	1.1	Зөвлөмж өгөх	2019.03.14		Захирал, Ерөнхий нягтлан бодогч О.Доржсүрэн, М.Баярмаа
9	Жижиг мөнгөн сантай холбоотой	3	Худалдан авалтын төсөв, дараа тайлангийн тооцоо, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл, захирлын зөвлөлөөс гаргасан шийдвэргүйгээр Жижиг мөнгөн сангаас зөөлөн эдлэл, шил шаазан, барилгын засварын материал зэргийг худалдаж авсан. /БНХАУ/	42.6	Зөвлөмж өгөх	2019.03.14		Захирал, Ерөнхий нягтлан бодогч О.Доржсүрэн, М.Баярмаа
			ЖМС-аас Үндсэн хөрөнгө худалдаж авсан. Гэр хотхонд 890000 төгрөг зарцуулж Нарантуулаас гэр худалдаж авсан.	0.9				
			Ерөнхий захирлын 2018/05/24-ны өдрийн А/53 тоот тушаалаар овоо тахихад хоолны зардлаас 619.0 мянган төгрөг, нэг	1.0				

			удаагийн буцалтгүй тусламж, шагнал урамшууллаас 440.0 мянган төгрөг нийт 1059.0 мянган төгрөг зарцуулсан байна. Тушаалд дурьдсан Хөдөлмөрийн дотоод журмын 12.2.5, Хамтын гэрээний 8.6.1 заалтуудтай тохирохгүй.					
10	Зардлын данстай холбоотой	2	2017 оны харшийн шинэ жилийн найруулагчийн хөлсийг 2018/01/05-нд олгож 2018 оны зардлаар тайлагнасан.	2.5	Зөвлөмж өгөх	2019.03.14	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	О.Доржсүрэн, М.Баярмаа
			Нүүрсний зарцуулалтыг тайлагнах журамын хэрэгжилтээр өдөр тутмын зарцуулалтыг 7 сараас бүртгэж эхэлсэн байна. Мөн нүүрсэг аж ахуйн материал дансанд бүртгэж байгаа. НБББББ-т заасны дагуу бүртгэх.					
	Нийт дүн	6		60.2				

